



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 1/38

Баян-Өндөр сум

Уралдаан зохион байгуулж хөрөнгө
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний 1.7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ой, "Энэ жилдээ Эрүүл жиндээ-2", "Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье аян"-ы хүрээнд төрийн болон байгууллагууд болон төрийн өмчит хувьцаат компанийн ажилтан албан хаагчдын дунд ажлын байрны дасгал зохион байгуулах цахим уралдааны удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Зардалд шаардагдах 175.000 (Нэг зуун далан таван мянга) төгрөгийг төсөл, хөтөлбөр, бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл, мэдээлэл, нягтлан бодохын ажилтан (Н.Чулуун-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.
3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг тайлагнаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төвийн ахлах мэргэжилтэн (А.Ганчимэг)-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 01 дүгээр сарын 13-ний
өдрийн 11 дугаар тушаалын
4 нэдүгээр хавсралт

9043446 2020030036

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАР ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ 100 ЖИЛИЙН ОЙ,
“ЭНЭ ЖИЛДЭЭ ЭРҮҮЛ ЖИНДЭЭ – 2”, “ХИЧЭЭЛЛЭЕ-ӨРНҮҮЛБЕ-ХЭВШЬЕ АЯН”-
Ы ХҮРЭЭНД ТӨРИЙН БОЛОН БАЙГУУЛЛАГУУД БОЛОН ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН АЖИЛТАН АЛБАН ХААГЧДЫН ДУНД АЖЛЫН
БАЙРНЫ ДАСГАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЦАХИМ УРАЛДААНЫ**

Нэг. Үндэслэл

Монгол Улсын хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаанд сүүлийн 5 жилийн байдлаар халдварт бус өвчин давамгайлж байна.

Манай улсад 15-69 насны хүн амын 21.9 хувь нь хөдөлгөөний хомсдолтой, суугаа идэвхгүй байдалд хоногт дунджаар 3.4 цагийг зарцуулдаг, 52.4 хувь нь ажлын байрандаа, 48.2 хувь нь амралт чөлөөт цагаараа эрүүл мэндэд тустай идэвхтэй хөдөлгөөн хийдэггүй, 49.4 хувь нь илүүдэл жин ба таргалалттай, 15-69 насны 3 хүн тутмын 1 нь халдварт бус өвчнөөр өвчлөх өндөр эрсдэлтэй байна.

Хоёр. Зорилго:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөн, Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Биеийн тамир, спортын салбарын 100 жилийн ойг угтаж, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үндсэн чиглэлд тусгагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэд, олон нийтийг идэвхтэй хөдөлгөөн, дасгал хөдөлгөөнд уриалж, хэвшүүлэх, дасгал хөдөлгөөнөөр хичээллэн өөрийгөө хөгжүүлэх сонирхол санаачилгыг нэмэгдүүлэх, эрүүл амьдралын дадал хэвшлийг бий болгоход оршино.

Гурав. Хамрах хүрээ:

3.1 Цахим уралдаанд төрийн байгууллагууд болон төрийн өмчит хувьцаат компанийн ажилтан, албан хаагчид оролцоно.

Дөрөв. Хугацаа:

4.1. 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл 2 сар цахимаар зохион байгуулагдана.

Тав.Хаана:

5.1. Дасгалыг тухайн байгууллагын ажилтан, албан хаагчид ажлын байрандаа хийж гүйцэтгэнэ.

Зургаа.Хэрэгжүүлэх арга хэмжээ:

6.1. Байгууллагын ажилтан, албан хаагчид "Ажлын байрны дасгал"-ыг өдөр бүр тогтмол цагт ажлын байрандаа хийх.

6.2. Ажлын байранд хийх дасгалыг тухайн байгууллага нь ажлын нөхцөл, онцлогоос хамааран өөрсдөө сонгоно.

6.3. Байгууллагууд өдөр бүр хийсэн дасгалын мэдээлэл, зураг бичлэгийг "Орхон аймаг БТСГ" фэйсбүүк группд байршуулж байх /Байгууллагын оролцоо, идэвх, тус арга хэмжээг хэрхэн зохион байгуулж буйг бүртгэнэ/

Долоо: Шалгаруулах журам:

7.1. Ажлын байрны дасгалыг өдөр бүр зохион байгуулсан байдал

7.2. Байгууллага хамт олон хийсэн дасгалаа "Орхон аймаг БТСГ" фэйсбүүк хуудсанд байршуулах, дасгалыг байршуулахдаа тухайн байгууллагын нэрийг тодорхой бичих.

7.3. Өдөр бүрийн дасгалд албан хаагчид бүрэн хамрагдсан байдал.

7.4. "Орхон аймаг БТСГ" фэйсбүүк группт байршуулсан нийт дасгалын тоо, тухайн байгууллагын нийт ажилчдын хэдэн хувь нь хамрагдсан байдал, дасгалыг хэрхэн хийсэн гүйцэтгэл зэргээр шалгаруулна.

7.5. Шалгаруулалтыг аймгийн Эрүүл мэндийн газар, Залуучуудын хөгжлийн төвтэй хамтран явуулна.

ХЯНАСАН: НЭМТАМ

А.ГАНЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН:ХБӨТСХМ

А.ХОНГОРЗУЛ

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 05 дүгээр сарын 18-ний
өдрийн 18 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

БИЕЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАР ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ 100 ЖИЛИЙН ОЙ,
“ЭНЭ ЖИЛДЭЭ ЭРҮҮЛ ЖИНДЭЭ -2”, “ХИЧЭЭЛЛЭЕ-ӨРНҮҮЛБЕ-ХЭВШБЕ АЯН”-
Ы ХҮРЭЭНД ТӨРИЙН БОЛОН БАЙГУУЛЛАГУУД БОЛОН ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН АЖИЛТАН АЛБАН ХААГЧДЫН ДУНД АЖЛЫН
БАЙРНЫ ДАСГАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЦАХИМ УРАЛДААНД ШААРДАГДАХ
ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Өргөмжлөл	Ширхэг	5	35.000₮*5	175.000₮
Нийт				175.000₮	

ХЯНАСАН: ССБНБА
БОЛОВСРУУЛСАН: ХБӨТСХМ



Н.ЧУЛУУН-ЭРДЭНЭ
А.ХОНГОРЗУЛ